

2019-10-14

ГЭРЭЭНИЙ БҮРТГЭЛ

БЕТОН ДЭР НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

Улаанбаатар хот

ХХат-19/239210/92
0Г/19/067

2019 оны 10 дугаар сарын 14 өдөр

Нэг талаас **Монгол-Оросын хувь нийлүүлсэн "Улаанбаатар Төмөр Зам" нийгэмлэг** (цаашид "Нийлүүлэгч" гэх) түүнийг төлөөлж Замын дарга Д.Жигжиднямаа, нөгөө талаас **"Монголын төмөр зам" ТӨХК** (цаашид "Захиалагч" гэх) түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал Р.Батсүх нар дараах нөхцөлөөр МУ-ын Иргэний хуулийг үндэслэн энэхүү гэрээг байгуулав.

Нэг. НИЙТЛЭГ ЗҮЙЛ

- 1.1 Энэхүү гэрээгээр чанар, стандартын шаардлага хангасан төмөр замын АРС маркийн бетон дэр /цаашид "бараа бүтээгдэхүүн" гэх/-ийг Нийлүүлэгчийн харьяа салбар нэгжийн агуулах нөхцөлөөр худалдах, Захиалагч нь төлбөрийг гэрээнд заасан нөхцөлөөр төлөхтэй холбоотой харилцааг зохицуулна
- 1.2 Нийлүүлэгчээс нийлүүлэх бараа, бүтээгдэхүүний ангилал, төрөл, нэгжийн болон нийт үнийг энэ гэрээний Хавсралт №1-д, нийлүүлэлтийн хуваарийг Хавсралт №2-т тодорхойлно.
- 1.3 Гэрээний хугацаанд нийлүүлэх нийт бараа бүтээгдэхүүний хэмжээ **52 000 /тавин хоёр мянга/ ширхэг** байна.
- 1.4 Талууд энэхүү гэрээгээр бараа, бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах итгэмжлэгдсэн төлөөлөгч буюу харилцах албан тушаалтныг тус тус томилох бөгөөд тэдгээртэй холбогдох мэдээллийг энэ гэрээний 8.6-д тодорхойлов.
- 1.5 Нийлүүлэгч бараа бүтээгдэхүүн ачуулах тухайгаа хуанлийн нэгээс доошгүй хоногийн өмнө Захиалагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчид, зайлшгүй тохиолдолд өөр холбогдох албан тушаалтанд утсаар буюу бусад хэлбэрээр мэдэгдэнэ. Нийлүүлэлт нь хэсэгчилсэн байдлаар хийгдэх бөгөөд ачилтын тоо хэмжээг тухай бүр Захиалагч талд утсаар мэдээлж, тоо хэмжээг тохирно.

Хоёр. ТООЦОО ХИЙХ ЖУРАМ

- 2.1 Бараа бүтээгдэхүүний нэгж үнэ 195 000,00 /нэг зуун ерэн таван мянга/ төгрөг бөгөөд гэрээний нийт үнэ 10 140 000 000,00 /арван тэрбум нэг зуун дөчин сая/ төгрөг болно.
- 2.2 Захиалагч тал гэрээний үнийн дүнгийн 50 хувийг гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш ажлын 3 өдрийн дотор нэхэмжлэхийн дагуу урьдчилан Нийлүүлэгчийн ХХБ 499201374 тоот дансанд шилжүүлнэ. Нийлүүлэлт хэсэгчилсэн байдлаар хийгдэх ба Захиалагч ачигдсан барааны тоо хэмжээг хүлээн авснаар акт үйлдэж ажлын 3 хоногийн дотор Нийлүүлэгчтэй тооцоо нийлж байна.
- 2.3 Энэ гэрээний 2.2-т заасан 50 хувийн төлбөрт ногдох бараа бүтээгдэхүүнийг Захиалагч хүлээн авсны дараа дараагийн бүтээгдэхүүнийг нийлүүлэхээс өмнө Нийлүүлэгчийн нэхэмжлэхийг хүлээн авснаас хойш ажлын 3 хоногийн дотор гэрээний үлдэгдэл 50 хувийн төлбөрийг дээр дурдсан дансанд урьдчилан шилжүүлсний дараа Гүйцэтгэгч нийлүүлэлтийг үргэлжлүүлнэ.
- 2.4 Тээвэрлэлт болон бусад зардлыг Захиалагч тал хариуцах ба тээврийн төлбөрийн тооцоог сар бүр нийлж, акт үйлдэн төлбөрийг УБТЗ-ын Санхүү нягтлан бодох бүртгэлийн албанд тээвэрлэлтийн бичиг баримтын дагуу төлнө.
- 2.5 Захиалагч бараа бүтээгдэхүүнийг хавсралт 2-т заасан хугацаанд хүлээн аваагүй тохиолдолд хадгалалтын хөлсийг Нийлүүлэгчид төлнө.

Гурав. "НИЙЛҮҮЛЭГЧ" ТАЛЫН ЭРХ, ҮҮРЭГ

Нийлүүлэгч нь дараах эрх үүргийг хэрэгжүүлнэ.

- 3.1 Гэрээний хугацаанд нийлүүлэх нийт бараа бүтээгдэхүүний хэмжээг төлөвлөсөн хэмжээнд хүргэнэ.

Нийлүүлэгчийг төлөөлж:

Захиалагчийг төлөөлж:

Энэхүү гэрээ нь байгууллагын нийцд хамтарих мэдээлэл тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагаг үлгүрчлөх аргаар этгээдэд хуульд заасны дагуу харилцааг хуульчлэх болно.



Хуулаас I

- 3.2 Бараа бүтээгдэхүүн ачуулсан тухай бүр акт үйлдэж Захиалагч талд утсаар мэдэгдэнэ.
- 3.3 Захиалагч талд хаяглан вагонд ачуулах бараа бүтээгдэхүүнийг ачилтад бэлтгэх ажлыг Нийлүүлэгч тал хариуцах ба Захиалагчаас төлбөрийг нэхэмжлэн авна.
- 3.4 Нийлүүлэгч тал нь энэхүү гэрээгээр тохиролцсон нөхцөлийн дагуу бараа бүтээгдэхүүний болон тээвэрлэлттэй холбоотой бусад зардлыг нэхэмжлэх эрхтэй.
- 3.5 Нийлүүлэгч тал нь энэхүү гэрээгээр тохиролцсон нөхцөлийн дагуу ачуулсан бүтээгдэхүүний хэмжээгээр акт үйлдэн Захиалагч талд хаяглан илгээх ба ачилтын тоо хэмжээг тухай бүрд Захиалагчид утсаар мэдээлнэ.
- 3.6 Нийлүүлэгч нь энэхүү гэрээний Хавсралт 1-д заасан техникийн тодорхойлолтын шаардлагын дагуу гүйцэтгэсэн бараа бүтээгдэхүүнийг хүлээлгэж өгнө.
- 3.7 Гэрээний дагуу нийлүүлэгдсэн бараа бүтээгдэхүүн нь тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулга, хувилбарыг хэрэглэнэ.
- 3.8 Хууль болон гэрээгээр хүлээсэн бусад эрх үүргийг хэрэгжүүлнэ.

Дөрөв. “Захиалагч” ТАЛЫН ЭРХ,ҮҮРЭГ

Захиалагч нь дараах эрх үүргийг хэрэгжүүлнэ.

- 4.1 Бараа бүтээгдэхүүнийг хүлээж авахдаа тоо, чанарыг шалгаж, холбогдох бичиг баримт, актыг бүрдүүлнэ.
- 4.2 Бараа бүтээгдэхүүний ачилт хийхээс өмнө Нийлүүлэгч талаас ирүүлсэн нэхэмжлэхийг үндэслэн энэ гэрээнд заасан нөхцөлийн дагуу тооцоо хийх үүрэгтэй.
- 4.3 Нийлүүлсэн бараа бүтээгдэхүүнийг хүлээн авах үед илэрсэн доголдлыг Нийлүүлэгчид 24 цагийн дотор мэдэгдэж холбогдох арга хэмжээг авна.
- 4.4 Нийлүүлж байгаа бараа бүтээгдэхүүний тээвэрлэлт, ачилт, буулгалт болон бусад холбогдох зардлыг Захиалагч тал хариуцна.
- 4.5 Захиалагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилж, Нийлүүлэгч талтай холбогдон бараа бүтээгдэхүүнийг тээвэрлүүлэх, ачих, буулгах, акт үйлдэх, төлбөр тооцоог барагдуулах зэрэг үйл ажиллагааг шуурхай зохион байгуулна.
- 4.6 Хууль болон гэрээгээр хүлээсэн бусад эрх үүргийг хэрэгжүүлнэ.
- 4.7 Гэрээнд заасан захиалгат бүтээгдэхүүнийг цаг тухайд нь акт үйлдэн хүлээн авах үүрэгтэй.

Тав. ТАЛУУДЫН ХАРИУЦЛАГА

- 5.1 Талууд гэрээний үүргээ биелүүлээгүйгээс нөгөө талдаа учруулсан хохирлыг бүрэн хариуцаж барагдуулна.
- 5.2 Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш гэрээний аль нэг тал нь хүлээсэн үүргийнхээ дийлэнх хэсгийг биелүүлж чадахгүй бодит нөхцөл бий болсон бол нөгөө талд мэдэгдэх бөгөөд нөгөө тал нь хүлээсэн үүргийн биелэлтээс татгалзах эрхтэй.
- 5.3 Энэ гэрээний үйлчлэх хугацаанд хүлээсэн үүргээ биелүүлэхээс нэг талын журмаар үндэслэлгүйгээр татгалзсан буруутай тал нөгөө талд гэрээ цуцалснаас үүдэн гарах хохирлыг хариуцан арилгана

Зургаа. МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ

- 6.1 Гэрээтэй холбоотой маргааныг талууд харилцан тохиролцох /зөвшилцөх/ зарчмаар шийдвэрлэнэ.
- 6.2 Талууд зөвшилцөлд хүрч чадахгүй бол Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу маргааныг шүүхээр шийдвэрлүүлнэ.

Долоо. ГЭНЭТИЙН БОЛОН ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

- 7.1 Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл (тухайлбал: үер, гал түймэр, газар хөдлөлт, халдварт өвчний тархалт зэвсэгт мөргөлдөөн, террорист үйлдэл, иргэдийн үймээн, ажил хаялт, төрийн (шийдвэр, оролцоо гэх мэт)-ийн нөхцөл байдлын шууд болон шууд бус үйлчлэлийн улмаас талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон

Нийлүүлэгчийг төлөөлж:

Захиалагчийг төлөөлж:

Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамгаарах мэдээлэл тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хуртгээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно.



7.1 Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл (тухайлбал: үер, гал түймэр, газар хөдлөлт, халдварт өвчний тархалт зэвсэгт мөргөлдөөн, террорист үйлдэл, иргэдийн үймээн, ажил хаялт, төрийн (шийдвэр, оролцоо гэх мэт)-ийн нөхцөл байдлын шууд болон шууд бус үйлчлэлийн улмаас талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд талууд зөвшилцөн гэрээний үйлчлэх хугацааг тухайн нөхцөл байдлыг арилгах хүртэл хойшлуулж болно.

Найм. БУСАД ЗҮЙЛ

- 8.1 Гэрээнд тусгагдаагүй аливаа харилцааг Монгол Улсын холбогдох хуулиар зохицуулна.
- 8.2 Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурж, Нийлүүлэгчийн Хууль зүйн албанд бүртгүүлж, баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
- 8.3 Тус гэрээ нь хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн Нийлүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж дуусах хүртэл хүчинтэй.
- 8.4 Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах болон гэрээг сунгах тохиолдолд талууд зөвшилцөн бичгээр үйлдэж, талууд гарын үсэг зурж, тамга дарснаар хүчин төгөлдөр болно.
- 8.5 Энэхүү гэрээг хоёр хувь үйлдсэн ба хувь тус бүр хуулийн адил хүчинтэй.
- 8.6 Нийлүүлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч:

Захиалагч:

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 1 дүгээр хороо, Нарны зам-62, Юнион бюлдинг, А блок, 7 давхарт
Утас: 70006622

Нийлүүлэгч:

Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 3 дугаар хороо, Сөүлийн гудамж-42, УБТЗ-ын УГ
Утас: 21-244404, 21-244400
Харилцах данс: ХХБанк 499201374

- 8.7 Хавсралт №1. Бараа бүтээгдэхүүний нэгж болон нийт үнэ, хэмжээ -1 хуудас.
Хавсралт №2. Бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтийн хуваарь -1 хуудас

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Нийлүүлэгчийг төлөөлж:

“УЛААНБААТАР ТӨМӨР
ЗАМ” ХНН-ИЙН ДАРГА



/Д.ЖИГЖИДНЯМАА/

Захиалагчийг төлөөлж:

“МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ” ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



/P.БАТСҮХ/

Нийлүүлэгчийг төлөөлж:

Захиалагчийг төлөөлж:

Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамаарах мэдээлэл тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно.

Хуудас 3



БЕТОН ДЭРНИЙ ҮНЭ

1. Талууд бетон дэрний нэгж үнийг урьдчилан тохиролцсон бөгөөд энэхүү хавсралт нь гэрээний салшгүй хэсэг байна.

№	Бараа	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ /төгрөг/	Дүн /төгрөг/
1	Бетон дэр APC	ширхэг	52000	195 000,00	10 140 000 000,00
	Нийт дүн				10 140 000 000,00

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Нийлүүлэгчийг төлөөлж:

УЛААНБААТАР ТӨМӨР
ЗАМ ХНН-ИЙН ДАРГА

/Д.ЖИГЖИДНЯМАА/

Захиалагчийг төлөөлж:

“МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ” ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

/Р.БАТСҮХ/

Нийлүүлэгчийг төлөөлж:

Захиалагчийг төлөөлж:

Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамаарах мэдээлэл тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно.

Хуудас 4

БАРАА БҮТЭЭГДЭХҮҮН НИЙЛҮҮЛЭХ ХУВААРЬ

1. Бараа бүтээгдэхүүнийг дараах хуваариар нийлүүлнэ. Үүнд:

Бүтээгдэхүүний нэр	10-р сар /ширхэг/	11-р сар /ширхэг/	12-р сар /ширхэг/	01-р сар /ширхэг/	02-р сар /ширхэг/	Нийт /ширхэг/
БЕТОН ДЭР АРС	6500	13000	13000	13000	6500	52000
Нийт дүн						52000

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Нийлүүлэгчийг төлөөлж:

УЛААНБААТАР ТӨМӨР
ЗАМ ХНН-ИЙН ДАРГА



/Д.ЖИГЖИДНЯМАА/

Захиалагчийг төлөөлж:

“МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ” ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТ ЭХ ЗАХИРАЛ



/Р.БАТСҮХ/

Нийлүүлэгчийг төлөөлж:

Захиалагчийг төлөөлж:

Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамаарах мэдээлэл тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хуртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно.



ОГ 119/067

....тоот гэрээг
бүртгэв.
УБТЗ-ын хуулийн зөвлөх
.....
2019 он 10 сар 14 өдөр
он .. сар .. өдөр